

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Урсгал засварт хэрэглэгдэх төрөл бүрийн барилгын материал /Багц 3/ нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДЦС4/2021-44-1**

**“ДЦС-4” ТӨХК** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Урсгал засварт хэрэглэгдэх төрөл бүрийн барилгын материал /Багц 3/”** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул **www.tender.gov.mn** хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1. Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. 2019, 2020 он тус бүрээр
- 2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
- 3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2019, 2020 тус бүрээр */нотлох баримтын хамт/*, сүүлийн 2 жил тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Хүчинтэй байх хугацаа: 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдөр дуустал

Тендерийг 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.


Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-13097000-1357

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХААХ-ЫН ДАРГА



ТӨМӨРХУЯГ

В.ЛХАГВАДОРЖ